Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
дарга 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

# НИЙГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГА ЛХАГВАА ОВОГТОЙ БАТТӨРИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэл-тийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| НЭГ. КОРОНАВИРУСТ ХАЛДВАР(КОВИД-19)-ЫН ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО | | | | | | | |
| **1.1 Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын арга хэмжээ** | | | | | | | |
| 1. | ЗГҮАХ 1.1.2.4 Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийг улирлын томуугийн вакцинд бүрэн хамруулах. | Вакцинжуулалтад хамрагдалтын хувь | Вакцинжуулалтын хамралтын хувь 92% байсан. | Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн 80%-аас доошгүй хувийг улирлын томуугийн вакцинжуулалтад бүрэн хамруулсан байна. | Монгол Улсын хэмжээнд томуугийн улирал угтуулан эрсдэлт бүлгийн хүн амыг дархлаажуулах зорилгоор томуугийн вакцин худалдан авахад шаардлагатай төсвийн хуваарийг Эрүүл мэндийн сайдын 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/23 дугаар тушаалаар баталсан.<br>НҮБ-ын Хүүхдийн санд 5,6 тэрбум төгрөгөөр томуугийн вакциныг захиалж, 2024 оны 8 дугаар сарын 21-ний өдөр 300,000 хүн/тун, нэмэлтээр 20,000 хүн/ тун вакциныг хүлээн авсан.<br>Эрүүл мэндийн сайдын 2024 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн А/359 дүгээр тушаалын дагуу 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн эрсдэлт бүлгийн хүн амыг дархлаажуулж байна. 2024 оны 12 дугаар сарын 05 өдрийн байдлаар улсын хэмжээнд зорилтот бүлгийн томуугийн вакцины хамралтын хувь 93.6%, үүнээс 0-5 насны хүүхдийн хамралтын хувь 89.1% байна. | 2024.01.022 024.12.31 | 90% |
| 2. | ЗГҮАХ 1.1.3.2 МУХТЖҮЧ 2.2.1 ЭМССТ 1.17 Шаардлагатай аймгуудад зоонозын | Байгуулсан ЗӨСТ болон хилийн боомтын тандалтын нэгжийн тоо | 3 аймагт ЗӨСТ, хилийн 12 боомтод тандалтын нэгж байгуулах | 2 аймагт ЗӨСТ, хил дагуух 10 боомтод тандалтын нэгж байгуулсан байна. | Өмнөговь аймгийн ЗӨСТ-ийн шинэ барилгын 3.4 тэрбум төгрөгийн төсвийг батлуулсан.<br>Хилийн боомтод тандалтын нэгж байгуулах асуудлаар мэдээлэл бэлтгэн, Хилийн | 2024.01.022 024.05.31 | 30% |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэл-тийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | өвчин судлалын төв, хил дагуух боомтод тандалтын нэгжийг тус тус байгуулах. | | тооцоо судалгаа хийгдсэн. | | боомтын захиргааны удирдлага, мэргэжилтнүүдтэй уулзалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, санал солилцсон. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль батлагдсантай холбогдуулан ХӨСҮТ, ЗӨСҮТ, НЭМҮТ-ийн тандалтын албыг нэгтгэн үндэсний түвшинд "Нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан үндэсний төв байгууллага", аймгуудад "Нийгмийн эрүүл мэндийн төв" байгуулах тул НЭМТ-ийн бүтэц, чиг үүрэгт зоонозын өвчний хяналт, сэргийлэлтийн асуудал хамаарахаар бодлогын хувилбарууд гарсан. | | |
| 3. | ЗГҮАХ 1.1.3.3 МУХТЖҮЧ 2.2.2 Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгаа зохион байгуулах. | Мэдээлэл, сургалт, сурталчилгааны тоо | Халдварт өвчнөөс сэргийлэх чиглэлээр инфографик, хөдөлгөөнт шторк, цуврал контент, текстэн зөвлөгөө | Төлөвлөгөөт сургалт сурталчилгаа бүрэн хийгдсэн байна. | Шинэ болон сэргэн тархаж буй халдварт өвчний мэдээлэл, сурталчилгааны ажлын 2024 оны нэгдсэн төлөвлөгөөг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр Дэд сайдаар батлуулж, 6/1362 дугаар албан бичгээр НЭМҮТ, ХӨСҮТ, ЗӨСҮТ-д хүргүүлсэн. Зудтай холбоотой үүсэх эрүүл мэндийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны төлөвлөгөөг 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдөр Эрүүл мэндийн Дэд сайдаар батлуулан хэрэгжүүлсэн. Халдварт өвчнөөс сэргийлэх чиглэлээр Дэлхийн банктай хамтран гарын эрүүл ахуйн чиглэлээр 4880, ЭМБ-ын хог хаягдлын талаар 2440, Халдварын дамжих замд суурилсан сэргийлэлтээр 2440, ЭМБ-ын цэвэрлэгээ, үйлчилгээний чиглэлээр 2440, цусаар дамжих халдварын чиглэлээр 2440 ширхэн постер хэвлүүлж, 21 аймаг, 9 дүүрэг, ЭМЯ-ны харьяа байгууллагуудад түгээсэн. | 2024.01.022 024.12.31 | 90% |



1142

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэл-тийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 4. | ЗГҮАХ 1.1.3.5<br>МУХТЖҮЧ 2.2.1<br>МУХТ 1.1.3.5<br>ЭМССТ 1.3<br>Өвчний хяналт, сэргийлэлтийн төв байгуулах ажлын хэсэгт ажиллах | Мэдээллээр хангаж ажилласан тоо<br>Ажлын хэсгийн үүрэг даалгаврыг биелүүлсэн хувь | - | Ажлын хэсгийн үүрэг даалгаврыг биелүүлсэн байна | Эрүүл мэндийн сайдын 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" А/37 дугаар тушаалын дагуу ажлын хэсэгт орж ажиллан Өвчний хяналт сэргийлэлтийн төвийн бүтэц болон дүрмийн төсөлд тухай бүрд санал өгч, мэдээллээр хангаж ажиллаж байна. | 2024.01.022 024.05.31 | 50% |
| 5. | ЗГҮАХ 1.1.3.1<br>Хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлнэ. | Нөөцийн бэлэн байдлын үнэлгээний тайлан | - | Үнэлгээний ажлын хэсгийн байгуулж, удирдамж, төлөвлөгөө батлуулсан байна.<br>Үнэлгээний тайлан гарч, нөөцийг шинэчилж сэлгэсэн байна. | Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн нөөцийн бэлэн байдалд хийх үнэлгээний ажлын удирдамж боловсруулан батлуулж, "Жагсаалт батлах тухай" ЭМС-ын 2023 оны А/211 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед эрүүл мэндийн салбарын нөөцөд байх эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйтгэлийн бодис, оношлуурын бэлэн байдалд НЭМБГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу СХГ, ЭЭХХЗГ-тай хамтран үнэлгээ хийсэн.<br>ЗӨСҮТ-ийн эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн агуулахад хадгалагдаж байгаа нөөцийн бэлэн байдалд үнэлгээ хийхэд хамгаалах хувцас хэрэгслийн нөөцөд нэг удаагийн комбинзон 23379 ш, нэг удаагийн халад 3872 ширхэг, цогцос хадгалах уут 67, ариутгал халдваргүйтгэлийн бодисын нөөцөд кальцийн гипохлорид 10тн, клорсепт 100 фл, аниозим прайм 125 фл, скинмэн софт 100 фл нөөцтэй байна.<br>Энэ нь ЭМС-ын 2023 оны А/211 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан 44 нэрийн эм, 36 нэрийн эмнэлгийн хэрэгсэл, 8 нэрийн хувийн хамгаалах | 2024.01.022 024.12.31 | 70% |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэл-тийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | хэрэгсэл, 7 төрлийн тоног төхөөрөмж, 3 нэрийн ариутгал халдваргүйжүүлэлтийн бодисын нөөц бүрдүүлээгүй байна. | | |
| **ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | |
| **2.1. Эрүүл мэнд, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.** | | | | | | | |
| 6. | МУХТЖҮЧ 2.2.2 ЭМССТ 1.9 Хүн амын дунд эрт илрүүлэг урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоо зохион байгуулах | Эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан хүн амын хувь | Хүн амын 38,9 хувийг эрт илрүүлэг үзлэг оношилгоонд хамруулсан. | Эрт илрүүлэг үзлэгт хүн амын 50 хувийг хамруулсан. | 2022 оны 05 сарын 01-ний өдрөөс 2024 оны 12 сарын 13-ны өдрийн байдлаар эрт илрүүлэг үзлэгт улсын хэмжээнд 1 569 815 хүн хамрагдсан нь нийт хамрагдвал зохих хүн амын 46.4 хувийг эзэлж байна. Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/150 дугаар тушаалаар урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, оношилгоо, шинжилгээг эрчимжүүлэх чиглэлээр 1.3 тэрбум төгрөгийн төсвийг баталж 868.65 сая төгрөгийн санхүүжилтийг УНТЭ, УХТЭ, УГТЭ-д олгосон. 2022 оноос хойш эрт илрүүлэг үзлэгт 87,9 тэрбум төгрөгийн зардлыг ЭМДЕГ-аас гаргасан байна.<br>Эрүүл мэндийн сайд, Боловсрол сайдын 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн А/413/А151 дугаар хамтарсан тушаалын дагуу хийгдэж буй 6 настны эрт илрүүлэгт нийслэлийн хэмжээнд 27,070 хүүхэд хамрагдсан. | 2024.01.02-2024.12.05 | 68% |
| 7. | Эрт илрүүлгийг эрчимжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулна. | Батлагдсан тушаал Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | | Төлөвлөгөө батлагдаж, төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна. | Эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээг эрчимжүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Эрүүл мэндийн сайдын 2024.01.29-ний өдрийн А/36 дугаар тушаалаар, Эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээг эрчимжүүлэх 9 зорилт, 43 үйл ажиллагаа бүхий цаглавар үйл ажиллагааны төлөвлөгөөг 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр, хамрагдалтыг нэмэгдүүлэх чиглэлээр ажлын дэд хэсэг байгуулах тухай удирдамжийг 2024 оны 02 | 2024.01.02-2024.12.05 | 100% |



5М

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэл-тийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | дугаар сарын 01-ний өдөр тус тус батлуулсан. Төлөвлөгөөний биелэлт 90%. | | |
| 8. | Эрт илрүүлгийн явуулын машины ашиглалтын журам батлуулна. | Батлагдсан тушаал | | Эрт илрүүлгийн явуулын машины ашиглалтын журмыг боловсруулж, батлуулна. | Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/71 дүгээр тушаалаар "Урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, шинжилгээ хийх тусгай зориулалтын автомашиныг ашиглах түр журам" батлуулсан. Явуулын эмнэлгийг ашиглан нийт 21910 хүнийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулсан. | 2024.01.02-2024.12.05 | 100% |
| 10. | ЗГҮАХ 2.1.5.5 Нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэхэд шаардлагатай дүрэм, стандартуудыг шинэчлэх | Шинээр батлагдсан дүрэм, стандартын тоо | - | Шаардлагатай стандарт, дүрэм, журам батлуулсан байна. | Монгол Улсын Засгийн газрын 2024.08.07-ны өдрийн "Засгийн газрын Үндэсний хороо, комисс, Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" 21 дүгээр тогтоолын 18 дугаар хавсралтаар "Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөл"-ийн бүрэлдэхүүн Ерөнхий сайдаар ахлуулан 25 хүний бүрэлдэхүүнтэйгээр батлагдсан.<br>Эрүүл мэндийн сайдын 2024.03.15-ны өдрийн А/124 дүгээр тушаалаар Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ, санхүүжүүлэх арга, төлбөртэй тусламж, үйлчилгээний төрөл, орлого, хандив тусламжийг зарцуулах журмын төслийг боловсруулсан бөгөөд олон нийтээс санал авч байна. https://moh.gov.mn/news/7197 | 2024.01.02-2024.12.05 | 30% |
| 11. | МУХТЖҮЧ-2.2.1 ЭМССТ 1.16 Шуурхай удирдлагын нэгж байгуулах. | Байгуулагдсан шуурхай удирдлагын нэгжийн тоо | 4 аймаг, 4 байгууллагад Шуурхай удирдлагын нэгж байгуулсан. | Шуурхай удирдлагын 6 нэгжийг байгуулсан байна. | Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль батлагдсантай холбоотойгоор Нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан үндэсний төв байгууллага болон аймаг, дүүрэгт байгуулах НЭМТ-ийн бүтэцэд ШУН байхаар хуульчлагдсан тул түр хойшилсон. | 2024.01.022024.05.31 | 30% |



146

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэл-тийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 12. | ДЭМБ-ын МонПЕН санаачилгын хүрээнд ХБӨ/ЗСӨ-өөс сэргийлэх, хянах нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний багцыг нэвтрүүлж хэрэгжүүлэх төслийг өргөжүүлэх | Багцыг хэрэгжүүлсэн аймаг, дүүргийн тоо | Төсөл 14 аймаг, 3 дүүрэгт хэрэгжсэн | Төслийг 7 аймаг, нийслэлийн 2 дүүрэгт хэрэгжүүлсэн байна. | МонПЭН санаачилгыг өргөжүүлэх тухай албан бичгийг хүргүүлж, үйл ажиллагааг хэрэгжүүлэх гэрээг ЭМС-аар батлуулсан.МонПЭН-ийг 7 аймаг, 6 дүүрэгт нэвтрүүлж, одоогийн үүссэн асуудлыг шийдвэрлэх Техникийн ажлын хэсгийг ЭМС-ийн 2024.10.21-ний өдрийн А/414 дугээр тушаалаар батлуулсан бөгөөд тус тушаалын хэрэгжилт 90%. Нийслэлийн 6 дүүрийн 112 АШЭМБ-д нэвтрүүлэх ажлын явц 90%-тай байна. | 2024.01.02-2024.12.05 | 70% |
| 13. | ЗГҮАХ 2.1.1.3<br>МУХТЖҮЧ 2.2.2<br>МУХТ 1.3.1<br>ЭМССТ 1.8<br>"Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд" арга хэмжээг хэрэгжүүлэх. | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | Арга хэмжээний хэрэгжилт 50 хувьд хүрсэн. | Арга хэмжээний хэрэгжилт 70 хувьд хүрсэн байна. | Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/760 дугаар тушаалаар "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд" арга хэмжээний төлөвлөгөөг 2021-2024 онд хэрэгжүүлэхээр баталж, 2024 онд 5 зорилтын хүрээнд 72 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс хэрэгжилт 80,1 хувьтай байна.<br>Улсын хэмжээнд 2024 оны 12 сарын 03-ны байдлаар 52514 эх төрж, 52830 хүүхэд амьд төрсөн байна. Амьгүй төрөлтийн түвшин 5.1 болж, өмнөх оны мөн үеэс 0.4 хувиар буурсан байна. Улсын хэмжээнд 11 эх эндэж, эхийн эндэгдлийн харьцаа өмнөх оны мөн үеэс 4.4 пунктээр буурсан байна. Харин тав хүртэлх насны 809 хүүхэд эндэж, эндэгдлийн түвшин 15.3 болж, өмнөх оны мөн үеэс 0.4 пунктээр өссөн бол нэг хүртэлх насны 645 хүүхэд эндэж, эндэгдлийн түвшин 12.2 болж, өмнөх оны мөн үеэс 0.1 пунктээр буурсан байна. Нярайн эндэгдэл 403 нярай эндэж, эндэгдлийн түвшин 7.6 болж, өмнөх оны мөн үеэс 0.4 пунктээр буурсан байна.. | 2024.01.02-2024.12.05 | 100% |
| 14 | ЗГҮАХ 2.1.1.4<br>МУХТЖҮЧ 2.2.2<br>МУХТ 1.3.1 | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | Арга хэмжээний хэрэгжилт 49.95 хувьд хүрсэн. | Арга хэмжээний хэрэгжилт 70 хувьд хүрсэн байна. | Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/360 дугаар тушаалаар "Хавдрын эсрэг" арга хэмжээний төлөвлөгөөг 2021-2024 онд | 2024.01.02-2024.12.05 | 39% |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэл-тийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | ЭМССТ 1.5 "Хавдрын эсрэг" арга хэмжээг эхлүүлж, хүн амын дунд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ зохион байгуулах. | | | | хэрэгжүүлэхээр баталж, 2024 онд 6 зорилтын хүрээнд 55.47 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд арга хэмжээний хэрэгжилт 55% -тай байна.<br>Улсын хэмжээнд 2024 оны 11 сарын байдлаар хорт хавдрын эрт илрүүлэх үзлэгийн хамралт Улсын хэмжээнд 2024 оны 11 сарын байдлаар Элэгний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 40-65 насны 304542 (33.4%) хүн хамрагдсанаас 64 тохиолдолд хорт хавдар оношлогдсон байна.<br>Умайн хүзүүний хорт хавдрын эсийн шинжилгээнд суурилсан эрт илрүүлэгт зорилтот насны нийт 77064 (35.1%) эмэгтэй хамрагдсан байна. Үр дүнгийн үзүүлэлтээр нийт эсийн шинжилгээний 3.7 хувь нь Пап эерэг буюу эсийн түвшинд өөрчлөлттэй. Үүнээс хорт хавдрын шинэ өвчлөлийн 29 тохиолдол бүртгэгдсэн байна.<br>Хөхний хорт хавдрын боломжит илрүүлэгт 483717 эмэгтэй хамрагдсанаас 1315 (0.3%) тохиолдол хөхний эмнэлзүйн үзлэгээр эерэг, хорт хавдрын шинэ өвчлөлийн тохиолдол бүртгэгдээгүй байна. | | |
| 15 | ЗГҮАХ 2.1.1.6 МУХТЖҮЧ 2.2.2 МУХТ 1.3.1 ЭМССТ 1.6 "Харшлаас сэргийлэх" арга хэмжээг хэрэгжүүлэх. | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | Арга хэмжээний хэрэгжилт 53 хувьд хүрсэн. | Харшлын шалтгаант өвчлөлийн түвшинг 30 хувиар бууруулсан байна. | Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/816 дугаар тушаалаар "Харшлаас сэргийлэх" арга хэмжээний төлөвлөгөөг 2021-2024 онд хэрэгжүүлэхээр баталж, 2024 онд 4 зорилтын хүрээнд 42 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс хэрэгжилт 64.5 хувьтай байна. | 2024.01.02-2024.12.05 | 70% |
| 16 | ЗГҮАХ 2.1.1.7 МУХТЖҮЧ 2.2.2 ЭМССТ 1.7 | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | Арга хэмжээний хэрэгжилт 50.6 хувьд хүрсэн байна. | Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан | Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/559 дүгээр тушаалаар "Эрүүл чийрэг эр хүн" арга хэмжээний төлөвлөгөөг 2021-2024 онд хэрэгжүүлэхээр баталж, 2024 онд 4 зорилтын хүрээнд 43 арга хэмжээ | 2024.01.02-2024.12.05 | 100% |



174

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэл-тийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | "Эрүүл чийрэг эр хүн" арга хэмжээ хэрэгжүүлэх. | | | эрэгтэйчүүдийн хувь 70-д хүрсэн байна. | хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс хэрэгжилт 75,6 хувьтай байна. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан иргэдийн 676,324 буюу 43.6 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна. Энэ нь зорилтот түвшний 62.8 хувийг эзэлж байна. 2024 оны байдлаар улсын хэмжээнд төрийн 23 эрүүл мэндийн байгууллагад урологи, андрологийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаагаас нийслэлд 12, аймаг 11 байна. | | |
| 17 | "Өсвөр үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах арга хэмжээний тухай" журмыг шинэчлэн батлуулах | Эрүүл мэндийн сайдын тушаал | Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/399 дүгээр тушаал | Тушаал батлагдсан байна | "Өсвөр үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах арга хэмжээний тухай журам"-ын төслийг эцэслэн боловсруулж дарга нараас өгсөн саналыг тусган батлуулахаар Эрүүл мэндийн сайдад 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр хүргүүлсэн. | 2024.01.02-2024.12.05 | 70% |
| 18 | Эрүүл мэнд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын хамтарсан "Оюутны эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг зохион байгуулах тухай" журмыг шинэчлэн батлуулах | Эрүүл мэндийн сайдын тушаал | Эрүүл мэндийн сайд, Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын сайдын хамтарсан 2018 оны 11 сарын 27 -ны А/480, А/739 тоот тушаал | Тушаал батлагдсан байна | Эрүүл мэндийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны хамтарсан "Оюутны эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг зохион байгуулах тухай" журам"-ын төслийг эцэслэн боловсруулж дарга нараас өгсөн саналыг тусган батлуулахаар Эрүүл мэндийн сайдад 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдөр хүргүүлсэн. Боловсролын сайд 2024.10.15-ны өдөр тушаалын төсөл дээр зурсан. | 2024.01.02-2024.12.05 | 70% |
| 19 | ЗГҮАХ 2.1.1.2 МУХТЖҮЧ 2.2.2 МУХТ 1.3.1 ЭМССТ 1.14 "Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх" арга хэмжээг хэрэгжүүлэх. | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | 2023 онд арга хэмжээний хэрэгжилт 70 хувьд хүрсэн. | Арга хэмжээний хэрэгжилт 80 хувьд хүрсэн байна. | Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/528 дугаар тушаалаар "Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх" арга хэмжээний төлөвлөгөөг 2022-2025 онд хэрэгжүүлэхээр баталж, 2024 онд 8 зорилтын хүрээнд 154 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба хэрэгжилт 72 хувь байна. | 2024.01.012024.12.31 | 90% |



149

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэл-тийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 20 | МУХТЖҮЧ-2.2.1 ЭМССТ 1.20<br><br>Товлолт дархлаажуулалтад хүний папилома вирусийн эсрэг вакцин нэвтрүүлэх. | Хүний папилома вирусийн эсрэг дархлаажуулалтад хамрагдсан 11 насны хүүхдийн эзлэх хувь | Засгийн газрын 2023 оны 472 дугаар тогтоол | Хүний папиллома вирусийн эсрэг дархлаажуулалтад хамрагдсан 11 насны хүүхдийн эзлэх хувь 75 хувьд хүрсэн байна. | Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/32 дугаар тушаалаар хүний папиллома вирусын эсрэг вакциныг дархлаажуулалтад нэвтрүүлэх нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажлын хэсгийн удирдамжийг, хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакцинаар дархлаажуулах 2024-2025 оны төлөвлөгөөг Эрүүл мэндийн сайдаар батлуулан хэрэгжүүлж байна.<br>Вакцин дархлаажуулалтын глобаль альянс байгууллагын техникийн дэмжлэгийн хүрээнд:<br>- "Хүний папиллома вирусийн халдвар, ХПВ-ийн халдварын эсрэг вакцины талаарх мэдлэг, хандлага, дадлын судалгаа"-г АШУҮИС-ийн НЭМС-тай хамтран НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр 5 аймаг, 2 дүүргийн нутаг дэвсгэрт байрлах ЕБС-ийн багш, сурган хүмүүжүүлэгч, эцэг эхчүүд болон эрүүл мэндийн байгууллагын эмч, ажилтнууд 3000 хүнийг хамруулан хийсэн.<br>- ЭМЯ-ны яамны мэргэжлийн салбар зөвлөл, эрүүл мэндийн ажилтан, ЕБС-ийн захирал, багш, эмч, нийгмийн ажилтан, хэвлэл мэдээллийн ажилтан болон шийдвэр гаргах түвшний нийт 5040 хүнийг сургалтад хамруулсан.<br>- НЭМҮТ-ийн мэдээллийн 119 тусгай дугаарын 12 ажилтныг сургаж, иргэдийг мэдээллээр хангаж байна.<br>- НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран нийт 8 төрлийн 212,600 ширхэг сурталчилгааны материал түгээгээд байна. | 2024.01.012 024.12.31 | 50% |



190

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэл-тийн хувь |
| 1 | | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | -Эрүүл мэндийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн "Хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакцинаар дархлаажуулах тухай" А/455 дугаар тушаалын дагуу товлолын насны хүүхдүүдийг 11 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн дархлаажуулж эхэлсэн ба 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар дархлаажуулалтын хамралт 20% байна. | | |
| 21 | БЗДХ, ХДХВ, ДОХ-оос сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө (2024-2026 он) боловсруулж батлуулах | Эрүүл мэндийн сайдын тушаал | Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөөний зорилт 4 | Төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан байна. | Эрүүл мэндийн сайдын 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн А/18 дугаар тушаалаар байгуулагдсан "БЗДХ, ХДХВ-ын халдварын эсрэг цогц арга хэмжээний өргөтгөсөн төлөвлөгөө боловсруулах" ажлын хэсгийг төлөвлөгөөний төслийг эцэслэн боловсруулж, ЭМЯ-ны газар, хэлтсийн дарга нараар хянуулсан.<br><br>"Өр хөрвүүлэх" хөтөлбөрийн 2025-2026 онд хэрэгжих үйл ажиллагаатай холбогдуулан БЗДХ, ХДХВ, ДОХ-оос сэргийлэх, хянах арга хэмжээний төлөвлөгөөг дахин шинэчлэх шаардлага бий болсон. | 2024.01.012<br>024.12.31 | 70% |
| 22 | ЗГҮАХ 2.1.1.2<br>МУХТЖҮЧ 2.2.1<br>"Элэг бүтэн Монгол" арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | Арга хэмжээний хэрэгжилт 70% хүрсэн байна. | Арга хэмжээний хэрэгжилт 80%-д хүрсэн байна. | Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/577 дугаар тушаалаар батлагдсан "Элэг бүтэн Монгол" арга хэмжээний төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 34 арга хэмжээг төлөвлөн 2022-2025 онд хэрэгжүүлж байна.<br>Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 63 хувьтай байна. | 2024.01.012<br>024.05.31 | 90% |
| 23 | МУХТЖҮЧ-2.2.1<br>Сүрьеэгээс сэргийлэх, хянах арга | Эрүүл мэндийн сайдын тушаал | Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга | Төлөвлөгөөг батлуулсан байна. | Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/537 дугаар тушаалаар байгуулагдсан "Сүрьеэ өвчний эсрэг цогц арга хэмжээний | 2024.01.012<br>024.07.30 | 70% |



191

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэл-тийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | хэмжээний төлөвлөгөө (2024-2026) боловсруулж батлуулах | | хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөөний зорилт 3 | | өргөтгөсөн төлөвлөгөө боловсруулах" ажлын хэсгийг төлөвлөгөөний төслийг эцэслэн боловсруулж, ЭМЯ-ны газар, хэлтсийн дарга нараар хянуулсан. "Өр хөрвүүлэх" хөтөлбөрийн 2025-2026 онд хэрэгжих үйл ажиллагаатай холбогдуулан БЗДХ, ХДХВ, ДОХ-оос сэргийлэх, хянах арга хэмжээний төлөвлөгөөг дахин шинэчлэх шаардлага бий болсон. | | |
| 24 | "Эрүүл шүд" (2024-2027) арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | - | Арга хэмжээний 2024 оны төлөвлөгөөний 60%-г хэрэгжүүлж, тайлан гарсан байна. | Эрүүл мэндийн сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн А/27/А25 дугаар хамтарсан тушаалаар "Эрүүл шүд арга хэмжээний төлөвлөгөө"-г 2024-2027 онд хэрэгжүүлэхээр баталж, 6 зорилтын хүрээнд 40 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба 2024 оны хэрэгжилт 67.5%-тай байна. | 2024.01.02-2024.12.05 | 100% |
| 25 | Эрүүл ахуйч, тархвар судлаачдын Үндэсний дөрөвдүгээр зөвлөгөөнийг зохион байгуулах | Зөвлөгөөн зохион байгуулсан байна. | Эрүүл ахуйч, тархвар судлаачдын Үндэсний III зөвлөгөөн | Эрүүл ахуйч, тархвар судлаачдын Үндэсний дөрөвдүгээр зөвлөгөөнийг зохион байгуулсан байна. | ДЭМБ санхүүжилтээр Эрүүл ахуйч тархвар судлаачдын Үндэсний дөрөвдүгээр зөвлөгөөнийг 2024 оны 12 дугаар сарын 04-05-ны өдөр зохион байгуулсан. Зөвлөгөөн "Ирээдүйн Төлөөх Шийдэл" уриан доор зохион байгуулагдаж 21 аймаг, нийслэлийн 9 дүүрэг, холбогдох мэргэжлийн байгууллага, ТББ-аас 150 орчим эрүүл ахуйч, тархвар судлаачид оролцож, нэгдсэн зөвлөмж гаргасан. | 2024.01.02-2024.12.05 | 100% |
| 26 | ЭМССТ 1.11 "Орчны эрүүл мэнд" арга хэмжээг хэрэгжүүлэх | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | Арга хэмжээний хэрэгжилт 60%-д хүрсэн. | Арга хэмжээний хэрэгжилт 70 хувьд хүрсэн байна. | "Орчны эрүүл мэнд" хөтөлбөрийг 2021-2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/349 дүгээр тушаалаар батлан, 2021-2024 онд нийт 72 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгасан. 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 80%-тай байна. | 2024.01.02-2024.12.05 | 80% |



154

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэл-тийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 27 | Агаарын тухай хуулийн 21.4 Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга байгууламжид ариун цэврийн хамгаалалтын бүс тогтоож, жагсаалт батлуулах. | Эрүүл мэндийн сайдын тушаал | Тушаалын төсөл боловсруулсан. | Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга байгууламжид ариун цэврийн хамгаалалтын бүс тогтоож, жагсаалт батлагдсан байна. | Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, Ерөнхий шаардлага MNS 5105:2001 стандарт"-д дурдагдаагүй орчиндоо эрсдэл бухий хүчин зүйл үүсгэн үйл ажиллагаа явуулдаг 14 чиглэлийн аж ахуйн нэгж, байгууллагад эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээг тогтоох Эрүүл мэндийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн тушаалаар батлуулсан. | 2024.01.02-2024.12.05 | 90% |
| 28 | Эрүүл мэндийн байгууллага бүр эрүүл мэндийн ажилтныг ажлын байрнаас шалтгаалсан халдвар авах нөхцөл, ажлын байрны эрсдэлийн байдалд үнэлгээ хийх нэгдсэн аргачлал боловсруулж, батлуулах | Эрүүл мэндийн сайдын тушаал | Нэгдсэн аргачлалын төсөл боловсруулсан. | Нэгдсэн аргачлалыг эцэслэн боловсруулж, батлуулсан байна. | Эрүүл мэндийн дэмжих сангийн 34,938,500 төгрөгийн санхүүжилтээр АШУҮИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн сургуультай хамтран эрүүл мэндийн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрсдэлийн үнэлгээ хийх нэгдсэн аргачлалыг (6 бүлэг, 45 асуулт бүхий) боловсруулж, АШУҮИС-Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлж батлуулсан.<br>Эрүүл мэндийн байгууллагад ажлын байрын орчны эрсдэлийн үнэлгээ хийх аргачлалыг хяналтын хуудсын хамт боловсруулж, Эрүүл мэндийн сайдын тушаалын төсөл боловсруулсан. | 2024.01.02-2024.12.05 | 70% |
| 29 | Угаарын хийн цочмог хордлогын тандалтын нэгжүүдийн бүртгэл, мэдээллийн чанарыг сайжруулах, чадавхижуулах арга хэмжээг зохион байгуулах | Бодит тоо, статистик мэдээ, зөвлөмж, уулзалт, сургалтын тоо | - | Угаарын хийн хордлогод өртсөн, нас барсан иргэдийн тоог гаргах, эрсдэлийг бодитоор үнэлэх, чадавхижуулах уулзалт, сургалтыг зохион байгуулсан байна. | НЭМҮТ-ийн Хор судлал, шуурхай удирдлагын алба, ЭМЯ-ны Хор судлалын мэргэжлийн салбар зөвлөлтэй хамтран Хими, нүүрстөрөгчийн дутуу ислийн цочмог болон архаг хордлогын үеийн тусламж үйлчилгээ, ялган оношлох, олныг хамарсан гамшиг ослын үед эмнэлгийн тусламжийг зохион байгуулах мэдлэг чадвар эзэмшүүлэх зорилгоор "Химийн бодис, нүүрстөрөгчийн дутуу ислийн хордлогын үеийн тусламж үйлчилгээ" | 2024.01.02-2024.12.05 | 50% |



154

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дуусан хугацаа | Биелэл-тийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | сэдвээр цахим сургалтыг 5 хичээлийн хүрээнд 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулж, 21 аймаг, 9 дүүргийн Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн төвүүд, нэгдсэн эмнэлгүүд, БОЭТ-ийн нийт 100 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан. | | |
| 30 | ЗГҮАХ 2.1.12.2 Ундны ус, ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулж, улсын хэмжээнд хэрэгжүүлэх | -Шинээр аудит эрсдэлийн үнэлгээ хийсэн байгууллагын тоо<br>-Ундны ус, ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулсан байгууллагын тоо | 16 аймгийн ус хангагч байгууллагад УАБТ-ний хэрэгжилтэд хөндлөнгийн аудит хийсэн. | Ундны ус, ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулах хэрэгжүүлэх ажлын удирдамж, төсвийг Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулна. | Ундны ус, ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулаагүй.<br>Төлөвлөгөө боловсруулахтай холбоотой 2024 оны 08 дугаар сарын 21-30-ны өдрүүдэд Говь-Алтай аймгийн Есөнбулаг, Баян-Уул сум, Баянхонгор аймгийн Бууцагаан сум, Ховд аймгийн Зэрэг суманд ДЭМБ-ын дэмжлэгтэйг үндэсний зөвлөхөөр бэлтгэгдсэн аудиторууд ажиллаж Усны аюулгүй байдлын төлөвлөгөөнд хөндлөнгийн аудит сонгогдсон сумын ус хангамжийн тогтолцоонд эрсдэлийн үнэлгээ, ус хангагч байгууллагын ажилчдад сургалт зохион байгуулж ажилласан. Үнэлгээний үйл ажиллагааны тайлан болон мөнгөн урьдчилгааны тайланг эцэслэн боловсруулж Төрийн нарийн бичгийн даргаар баталгаажуулан ДЭМБ-д хүргүүлсэн | 2024.01.02-2024.12.05 | 100% |
| 31 | ЗГҮАХ 2.3.10.1 Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрын стандартын хэрэгжилтийг | Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан | "MNS 7005: 2023 Ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд | Стандартыг хэрэгжүүлэхэд хамтран ажиллана. | Стандарт хэмжил зүйн газрын 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн "MNS 7005: 2023 Ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих шаардлага" стандарт шинээр батлагдсан ба тус стандартыг 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөж байна.<br>"Сургуулийн хоол үйлдвэрлэлд тавих хяналтын журам" батлах тухай Боловсрол, | 2024.01.02-2024.12.05 | 100% |



191

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэл-тийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | хангахад хамтран ажиллах | | тавих шаардлага" | | шинжлэх ухааны сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайд нарын 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн А/78, А/238, А/173 дугаар хамтарсан тушаалыг батлуулж, Захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн сангийн 6836 дугаарт 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдөр бүртгүүлсэн.<br>Дээрх журам батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Шадар сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтран баталсан 2022 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 28/А/108/А/180 дугаар тушаалыг 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 44/А/308/А/291 дүгээр хамтарсан тушаалаар хүчингүй болгосон. | | |
| 32 | ЗГҮАХ 2.3.4.6 Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн онцлог, суралцах чадамжид суурилан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, үнэлгээний арга зүйг боловсронгуй болгох | Хүргүүлсэн санал | Сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан. | Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, үнэлгээний арга зүйг боловсронгуй болгох, сурах бичгийг хүртээмжтэй болгоход чиг үүргийн дагуу оролцоно. | Боловсролын яам, ЖАЙКА Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай хамтран "Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн үйлчилгээг сайжруулах төсөл"-ийн хүрээнд 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулагдсан "Тэгш хамран сургах боловсрол: сургамж, анхаарах асуудал" семинарт хамтран оролцож, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, тусламж үйлчилгээний талаар баримталж буй бодлого, хэрэгжилтийн талаар илтгэл мэдээлэл танилцуулж, тэгш хамран сургах боловсролыг хэрэгжүүлэх арга зүйг боловсронгуй болгох асуудлаарх хэлэлцүүлэгт оролцож, сургалтын хөтөлбөрт санал хүргүүлсэн. | 2024.01.02-2024.12.05 | 100% |
| 33 | ЗГҮАХ 2.3.8.5 | Сургагдсан багшийн тоо | 165 багшийг мэргэшүүлсэн. | 165 багшийг мэргэшүүлэх | Боловсрол, шинжлэх ухааны яам, Азийн Хөгжлийн Банк хамтран хэрэгжүүлж буй | 2024.01.02-2024.12.05 | 100% |



195

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дуусан хугацаа | Биелэл-тийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | Ерөнхий боловсролын сургуулийн багшийг тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр мэргэшүүлэх | | | сургалтад хамруулна. | "Тэгш хамруулах боловсролыг дэмжих төсөл"-ийн хүрээнд төслийн зорилтот аймгууд болох Дархан-Уул, Дундговь, Дорнод аймгийн 100 багш, цэцэрлэг, сургуулийн удирдах ажилтанд тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээрх сургалтыг 2024 оны 03 дугаар сарын 04-06-ны өдрүүдэд зохион байгуулсан.<br>"Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төсөл"-ийн хүрээнд тэгш хамруулах боловсрол, хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт мэдлэг, нэмэгдүүлэх, ганцаарчилсан сургалтын хөтөлбөр боловсруулах сургалтыг 2024 оны 09 дүгээр сарын 17-27-ны өдрүүдэд зохион байгуулж, бага, дунд ангийн 65 багш, удирдах ажилтныг хамруулсан. | | |
| 34 | Эхийн сүүний нөөцийн банк байгуулах, ажиллуулах журмыг батлуулах | Эрүүл мэндийн сайдын тушаал | Журмын төсөл боловсруулж байгууллагуудаас санал авсан. | Журмыг Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулсан байна. | Эхийн сүүний нөөцийн банкны журмын төсөл боловсруулах ажлын хүрээнд ЭМЯ, НЭМҮТ, НҮБ-ын Хүүхдийн сангийн төлөөллийг оролцуулсан уулзалт зохион байгуулж, ажлын төлөвлөгөө гаргасан. Журмын эхний төслийг боловсруулж, холбогдох газруудаас санал авах албан бичгийг хүргүүлсэн. ЭХЭМҮТ, ЭНЭҮТ-2, Өргөө, Хүрээ амаржих газрууд, Интермед эмнэлгээс ирүүлсэн саналыг тусган эхийн сүүний нөөцийн банк байгуулах журмын төслийг эцэслэн боловсруулж, газар хэлтсийн дарга нараар хянуулан тойруулж байна. | 2024.01.02-2024.12.05 | 70% |
| 35 | ЗГҮАХ 2.3.2.6 Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх, бусад | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | 2023 оны БШУ-ны сайд, ЭМ-ийн сайд, ХНХ-ын сайдын А/236, А/189, А/80 дугаар | Арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хэрэгжүүлсэн байна. | Эрүүл мэндийн салбарын хариуцах төлөвлөгөөний хэрэгжилт 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 80%-тай байна.<br>2024 оны 03 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулагдсан "Бага насны | 2024.01.02-2024.12.05 | 100% |



156

